				09	2	3	01	02	Нийгмийн ажил, эрүүл мэндийн	E	F	Social work, health
			1011 Гэрийн болон ахуйн үйлчилгээ	10	1	1	01	01	Ахуйн үйлчилгээ	E		Domestic services
			1013 Зочид буудал, ресторан, нийтийн хоол	10	1	3	01	01	Зочлох үйлчилгээ	E		Hospitality
			1014 Спорт	10	1	4	01	01	Спортын дасгалжуулагч	E		Sports coach
			1015 Аялал, жуулчлал, чөлөөт цаг	10	1	5	01	01	Аялал жуулчлал	E	F	Tourism
		10	1	5	01	03	Чөлөөт цаг, соёлын ажлын арга зүй	E		Leisure and culture work methodology		
102 Хамгааллын үйлчилгээ	1021 Нийтийн ариун цэвэр	10	2	1	01	01	Нийтийн ариун цэвэр	E		Community sanitation		
	1022 Хөдөлмөрийн эрүүл мэнд, хамгаалал	10	2	2	01	01	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал	E	F	Occupational health, safety		
	1031 Цэрэг, батлан хамгаалах	10	3	1	01	01	Батлан хамгаалах судлал	E	F	Defense studies		



Ерөнхий судлагдахуун	Төрөлжсөн судлагдахуун	Нарийвчилсан судлагдахуун	Индекс				Хөтөлбөрийн нэр	Магистр	Доктор	Name of program			
			10	3	1	01							
10 ҮЙЛЧИЛГЭЭ	103 Аюулгүй байдлыг хангах үйлчилгээ		10	3	1	01	02	Зэвсэгт хүчний байгуулалт	E	F	Armed forces building		
			10	3	1	01	03	Цэргийн урлаг (стратег, оператив, тактик)	E		Military art (Strategy, operative, tactic)		
			10	3	1	01	04	Дайн, цэргийн урлаг судлал		F	War and warfare studies		
			10	3	1	01	05	Цэрэг захиргааны удирдлага (ХЗЦ-ийн, АДХ-ийн, ХЦ-ийн, ТТМЦ-ийн)	E		Master of business administration (Defense)		
			10	3	1	01	06	Цэргийн удирдлага		F	Defense leadership		
			10	3	1	01	07	Төрөл, тусгай мэргэжлийн цэргийн урлаг	E		Military art of specialist		
			10	3	1	01	08	Дайны бус цэргийн ажиллагаа		F	Noncombat operation		
			10	3	1	01	09	Байлдааны техник, зэвсгийн инженерчилэл	E		Vehicle and weapon engineering		
			10	3	1	01	10	Цэргийн сэтгэл зүйн хангалт	E		Military psychological support		
			10	3	1	01	11	Цэргийн материал, техникийн хангалт	E		Military material and technical support		
			10	3	1	01	12	Цэргийн сургалт судлал	E	F	Studies of military education		
			10	3	1	01	13	Цэргийн түүх судлал	E	F	Military history		
			10	3	1	01	14	Хуягт танкийн техник	E		Armored technics		
			10	3	1	01	15	Цэргийн авто, гинжит машин	E		Military vehicle technology		
			10	3	1	01	16	Цэргийн зэвсэглэл, техник судлал	E	F	Military technology		
			10	3	1	01	17	Байлдааны хангалт	E		Combat support		
			10	3	1	02	01	Артилерийн зэвсэглэл	E		Armament of Artillery		
			10	3	1	03	01	Зенитийн пуужингийн зэвсэглэл	E		Guided weapon systems		
			10	3	1	04	01	Зенитийн артиллери-электроник	E		Air defense artillery		
			10	3	1	05	01	Цэргийн зэвсэглэл	E		Gun systems design		
			10	3	1	06	01	Холбооны техник, хэрэгсэл	E		Communications		
			10	3	1	06	02	Цэргийн удирдлагын автоматжуулалт	E		Defence simulation and modelling		
			10	3	1	07	01	Цэргийн химийн техник, зэвсэг	E		Military chemical technics		
			10	3	1	08	01	Радиотехник	E		Radio technics		
			10	3	1	09	01	Цэргийн инженерийн техник	E		Military engineering technics		
			10	3	1	09	02	Цэргийн зам, гүүрийн инженер	E		Military engineering of roads and bridges		
			10	3	1	09	03	Цэргийн тусгай барилга байгууламж	E		Military special installation		
			1032 Иргэн, өмч хөрөнгө хамгаалал		10	3	2	01	01	Гэмт явдал судлал-эрх зүй	E	F	Criminal justice and criminology
					10	3	2	01	02	Цагдаа судлал	E	F	Police studies
					10	3	2	01	03	Хууль сахиулах удирдлага	E	F	Law enforcement administration
					10	3	2	01	04	Цагдаагийн стратеги тактик удирдлага	E		Police management
					10	3	2	02	01	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги- тактик, удирдлага	E		Court decision execution management
					10	3	2	03	01	Мөрдөх алба	E		Criminal investigation
					10	3	2	04	01	Шинжлэн магадлах ухаан	E	F	Forensic science
					10	3	2	05	01	Гамшиг судлал	E	F	Disasterology
					10	3	2	05	02	Онцгой байдлын стратеги-тактик, удирдлага	E		Emergency management
					10	3	2	06	01	Шалган нэвтрүүлэх алба	E		Border control service
			1036 Аюулгүй байдлыг хангах үйлчилгээний салбар дундын хөтөлбөр		10	3	8	01	01	Аюулгүй байдал судлал	E	F	Security studies
					10	3	8	01	02	Мэдээллийн аюулгүй байдал	E		Cyber security
					10	3	8	01	03	Эдийн засгийн аюулгүй байдал	E		Economic security
					10	3	8	01	04	Тагнахуйн ухаан	E		Intelligence studies
					10	3	8	02	01	Хил судлал	E	F	Border studies /frontlogy/
					10	3	8	02	02	Хилийн стратеги-тактик, удирдлага	E		Border strategy and tactics, management
					10	3	8	02	03	Боомтын аюулгүй байдлын алба	E		Border control security service
			104 Тээврийн үйлчилгээ	1041 Тээвэр	10	4	1	01	01	Тээврийн үйлчилгээ	E		Transport services
			10	27	76					419	416	257	



МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТ ЭРХЛЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү нийтлэг журмын зорилго нь их, дээд сургууль (цаашид “сургууль” гэнэ)-д магистр, докторын сургалт эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сургуулийн хэмжээнд баримтлах магистр, докторын сургалтыг зохион байгуулахад баримтлах журам (цаашид “сургалтын журам” гэнэ)-ыг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, тухайн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн сургуулийн захирал батална.

1.3. Магистр, докторын сургалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрөл бүхий хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

1.4. Дээд боловсролын магистр, докторын түвшний сургалт, судалгааны ажлын агуулга, зохион байгуулалтыг тодорхойлсон цогц баримт бичгийг хөтөлбөр гэнэ.

1.5. Магистр, докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь олон улсад нийтлэг тогтсон зарчимд нийцсэн, эрдмийн эрх чөлөөг хангахад чиглэсэн байна.

Хоёр. Хөтөлбөрт тавих шаардлага

Хөтөлбөр нь сургуулийн хэв шинж, мэргэших чиглэлээс үл хамааран түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүнг хянах, үнэлэхэд баримтлах үзэл баримтлал, зарчим, хүрэх үр дүнг илэрхийлсэн, дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

2.1. Магистр, докторын хөтөлбөр нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

- Хөтөлбөрийн танилцуулга
- Сургалтын төлөвлөгөө
- Хичээлийн хөтөлбөр
- Хөтөлбөрийн зохион байгуулалт
- Суралцах орчны шаардлага
- Элсэгчдэд тавих шаардлага
- Багшлах бүрэлдэхүүнд тавих шаардлага
- Төгсөгчдийн эзэмших ур чадвар
- Суралцагчийн үнэлгээ
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт.

2.2. Хөтөлбөрийн танилцуулга

- 2.2.1. Хөтөлбөрийн нэр, индекс (оноосон нэрийг монгол, англи хэлээр бичнэ)
- 2.2.2. Хөтөлбөрийг албан ёсоор баталгаажуулсан, магадлан итгэмжилсэн, хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн тухай мэдээлэл
- 2.2.3. Хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ
- 2.2.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр хүрэх үр дүн (төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, чадамж)
- 2.2.5. Хөтөлбөрийг хариуцах нэгж, хороо, захирал, харилцах хаяг

2.3. Сургалтын төлөвлөгөө

2.3.1. Магистр, докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд хөтөлбөрийн агуулгад холбогдох хичээлийн бүлэглэл, хичээл бүрд харгалзах багц цаг, хичээлийг судлах дараалал болон хоорондын холбоог тусган, хөтөлбөрийн тавих шаардлагыг хангасан байдлыг хэрхэн тооцохыг тодорхойлсон байна.

2.3.2. Магистрын хөтөлбөр нь 30 багц цагаас доошгүй байна. Хөтөлбөр нь дараах хичээл, судалгааны багц цагаас бүрдэнэ.

- i. Мэргэжлийн суурь хичээл нийт 10 багц байна. Үүнээс 4 багц цагийг судалгааны арга зүйн хичээл, 6 багц цаг нь тухайн хөтөлбөрийн онолын үндсэн хичээлүүд байна.
- ii. Мэргэшүүлэх хичээл 12 багц цагаас доошгүй байна. Үүнээс 9 багц цагийг тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, профессорын баг, бусад нэгжээс, 3 багц цагийг бусад тэнхим, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгон судална.
- iii. Магистрын ажил бичсэн тохиолдолд профессорын багийн судалгааны болон онолын семинарыг удирдагч багшийн удирдлаган дор хариуцан зохион байгуулахад 3 багц цаг байна.
- iv. Магистрын ажил бичсэн тохиолдолд магистрын ажлыг 5 багц цагаар тооцно.
- v. Магистрын ажил бичихгүй тохиолдолд мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлээс 10 багц цаг сонгон судална.

2.3.3. Докторын хөтөлбөр нь 60 багц цагаас доошгүй байна. Докторын хөтөлбөр нь дараах хичээл, судалгааны багц цагаас бүрдэнэ.

- i. Мэргэжлийн суурь хичээл нийт 12 багц байна.
- ii. Мэргэшүүлэх хичээл 18 багц цаг байна. Үүнээс 12 багц цагийг тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, нэгжээс, 6 багц цагийг бусад тэнхим, профессорын баг, бусад нэгж, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгон судална.
- iii. Профессорын багийн судалгааны болон онолын семинарыг удирдагч багшийн удирдлаган дор хариуцан зохион байгуулахад 6 хүртэл багц цаг байна.
- iv. Докторын ажил 24 багц цаг байна.

2.3.4. Магистр, докторын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг холбогдох хөтөлбөрийн хороо боловсруулан, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснийг үндэслэн сургуулийн захирал батална.

2.3.5. Магистрант, докторантын хөтөлбөрийн гүйцэтгэлд бусад сургуульд хуримтлуулсан багц цагийг дүйцүүлэн тооцох асуудлыг сургуулийн сургалтын журамд нарийвчлан тусгана. Ийнхүү дүйцүүлэн тооцоход сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн байдал, хөндлөнгийн үнэлгээний дүнг харгалзана.

2.3.6. Магистрант нь бие даасан судалгааны ажил гүйцэтгэн магистрын ажил бичиж, “Магистрын ажил хамгаалуулах зөвлөл”-д хамгаална.

2.3.7. Магистрант нь магистрын ажил бичихгүйгээр мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлээс 10 багц цаг сонгон судалж, нэгдсэн шалгалт өгч болно. Энэ тохиолдолд нэгдсэн шалгалтад багц цаг тооцохгүй.

2.3.8. Докторант нь бие даан гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнг эмхтгэн докторын ажил /диссертаци/ бичиж, “Докторын ажил хамгаалуулах зөвлөл”-д хамгаална.

2.3.9. Магистр, докторын ажил хамгаалуулах зөвлөлийн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

2.4. Хичээлийн хөтөлбөр

2.4.1. Хичээлийн нэр, зорилго, хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн (магистрант, докторантын эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, чадамж), энэхүү хичээлийг судлахын өмнө судалсан байвал зохих (prerequisite) хичээлийн тухай үндсэн мэдээлэл

2.4.2. Хичээлийн үндсэн агуулга, хичээллэх өдөр бүрээр төлөвлөсөн судлах зүйлийн тойм, холбогдох эх сурвалж, гүйцэтгэх даалгавар

2.4.3. Суралцагчийн гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх арга хэлбэр, үнэлгээний хуваарь

2.4.4. Хичээлийг заах багшийн нэр, харилцах хаяг.

2.5. Хөтөлбөрийн зохион байгуулалт

2.5.1. Суралцах үйл ажиллагаа нь суралцагч төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сурах, хөтөлбөрт суурилсан, идэвхтэй арга хэлбэрийг зохистойгоор хослуулсан байна.

2.5.2. Мэдээлэл харилцааны дэвшилтэт технологи ашиглах, он-лайн нээлттэй эхийг уламжлалт сургалтанд ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

2.5.3. Ажлын байранд хүлээгдэж буй шаардлагын дагуу дадлагажих, нийтийн сайн сайхны төлөө үйлчлэх замаар хамтдаа ажиллаж, амьдрахад суралцахад боломж олгосон байна.

2.5.4. Судалгааны ажил хийх үйл ажиллагаа нь академик эрх чөлөөг хүндэтгэсэн байна.

2.5.5. Докторант нь хичээлээр авах багц цагийг судалсны дараа докторын судалгааны ажлаа эхлүүлэхийн өмнө нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалтыг зохион байгуулалтын талаар сургуулийн сургалтын журамд тусгана.

2.5.6. Магистрант, докторантын гүйцэтгэх судалгааны ажлын чиглэл, мөн чанарыг тусгасан аргачлал, төлөвлөгөөг боловсруулах, батлах, өөрчлөлт оруулах асуудлыг сургуулийн сургалтын журамд тусгана.

2.5.7. Магистр, докторын ажлын агуулга, бүтцэд тавих шаардлага, загварыг сургууль батална.

2.5.8. Магистрант, докторантаар суралцуулах тухай сургуулийн захирлын тушаал гарснаар элсэгчийг тухайн сургуульд элссэнд тооцно. Тушаалд суралцуулах хөтөлбөрийн нэрийг тодорхой заасан байна.

2.5.9. Элсэлтийг хичээлийн жилийн улирал эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө дуусгасан байна.

2.6. Суралцах орчны шаардлага

2.6.1. Сургалтын тусгай зөвшөөрөл болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх байгууллагын тогтоосон шаардлагад нийцсэн материаллаг болон материаллаг бус орчинг бүрдүүлсэн байна.

2.7. Элсэгчдэд тавих шаардлага

2.7.1. Магистрын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын боловсрол, түүнтэй дүйцүүлэх боловсрол, докторын хөтөлбөрт элсэгч нь магистрын боловсрол эзэмшсэн байна.

2.7.2. Элсэгч өмнө эзэмшсэнээс өөр чиглэлээр магистр, докторын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах хичээлийн зөрүүг нөхөн үзнэ. Нөхөж үзсэн хичээлийг магистр, докторын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.

2.7.3. Хөтөлбөрийн онцлогоос хамааран элсэгчдэд тавих бусад нэмэлт шаардлагыг сургууль тогтоож болно.

2.7.4. Элсэлтийн шалгалтыг зохион байгуулах журмыг сургууль тогтооно.

2.7.5. Гадаадын суралцагч монгол хэлээр сургалтад хамрагдах шаардлагыг хангасан байна. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу суралцуулахад хэлэлцээрт заасан нөхцлийг баримтална.

2.8. Багшлах бүрэлдэхүүнд тавих шаардлага

2.8.1. Магистр, докторын сургалтын багшид тавих шаардлага нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журмын”-ын шаардлагад нийцсэн байна.

2.8.2. Үйлдвэрлэл практикийн туршлагатай, өндөр мэргэшсэн багшийг холбогдох чиглэлээр зочин багшаар урьж болох бөгөөд энэ тохиолдолд албан ёсны гэрээ байгуулан ажиллана.

2.8.3. Магистрын ажлын удирдагч нь докторын зэрэгтэй, их, дээд сургууль эсхүл эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, энэхүү журмын 3.1.5-д заасан эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлтэй, идэвхтэй судлаачид байна.

2.8.4. Докторын ажлын удирдагч нь энэхүү журмын 2.8.3-т заасан шаардлагаас гадна тухайн мэргэжлийн чиглэлээрээ сүүлийн 3 жилд 1-ээс цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн, идэвхтэй судлаач байна.

2.8.5. Суралцах, судалгаа хийх үйлийг үр дүнтэй удирдах технологи арга зүйг эзэмшсэн байна.

2.8.6. Багш, удирдагчид тавих нэмэлт шаардлагыг сургууль тодорхойлно.

2.9. Төгсөгчдийн эзэмших ур чадвар

2.9.1. Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал, төлөвшил

- i. Шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх чадвар. (Асуудлыг тодорхойлж, баримт нотолгоонд үндэслэн дүн шинжилгээ хийж, зүй тогтлыг илрүүлэх, тандан судлах, хөгжлийн хандлагыг тодорхойлох, шинэ санаа гаргах, зураглах, боломжит хувилбарыг сонгож илэрхийлэн харуулах)
- ii. Шинжлэн судлах, шийдэл гаргах (Таамаглал дэвшүүлэн харьцуулсан судалгаа, анализ хийх, загварчилж баримт бичиг боловсруулах)
- iii. Системтэй төлөвлөх (Мэргэжлийн сэтгэлгээгээр хандах, хоорондоо хамааралтай зүйлсийг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг нь ойлгох, ач холбогдлоор нь ангилан чухал санаан дээр төвлөрч шалгах, харьцуулан сонгох)
- iv. Хувь хүний ур чадвар ба дадал (Шинийг санаачлах эрмэлзэлтэй, уламжлалыг дээдлэн уян хатан бүтээлч сэтгэлгээтэй байх, хувь хүний мэдлэг, ур чадвар, төлөвшлийг үнэлж ухамсарладаг, бие даан суралцах, цагийн болон нөөцийн менежментийг зөв хэрэгжүүлдэг байх)
- v. Мэргэжлийн ур чадвар, төлөвшил (Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйтэй, хариуцлагатай, чадвартай, эдийн засгийн тооцоотой байх, тасралтгүй судалгаа хийж, идэвхтэй судлаач байж шинэ мэдлэг, мэдээллийг бий болгон шинжлэх ухаанд хувь нэмрээ байнга оруулах)

2.9.2. Харилцааны ур чадвар (Багаар ажиллах чадвар ба харилцаа)

- i. Багаар ажиллах (Баг бүрдүүлэх, багийг удирдах, төслийн менежментийг хэрэгжүүлэх, манлайлах ур чадвартай байх)
- ii. Харилцааны чадвар (Харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мультимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах үндсэн ур чадвартай байх)
- iii. Гадаад хэлээр харилцах (Англи болон бусад гадаад хэлээр мэргэжлийн мэдээлэл ашиглах, илтгэх, бичих чадвартай байх)

2.9.3. Мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, чадамжийг сургууль тодорхойлно.

2.10. Суралцагчийн үнэлгээ

2.10.1. Хичээл бүрийн үнэлгээний зэрэгцээ хөтөлбөрийн үндсэн үе шат бүрийн үр дүнг дараах хэлбэрээр үнэлнэ.

- i. Явцын үнэлгээ
- ii. Улирлын үнэлгээ
- iii. Ур чадварын үнэлгээ
- iv. Бусад үнэлгээ

2.10.2. Үнэлгээ нь суралцах үйл явцыг дэмжсэн бодитой, үнэлгээний нийтлэг жишигтэй харьцуулах боломжтой байна.

2.10.3. Хөтөлбөрийн үр дүн нь мэргэжлийн эрх олгохтой холбогдох тохиолдолд харгалзах мэргэжлийн шалгалтын үнэлгээний аргачлалтай нийцэхүйц байна.

2.10.4. Сургууль суралцагчийг зарим хичээлд С буюу түүнээс дээш дүн авсан байх шаардлага тавьж болно.

2.11. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт

2.11.1. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хөтөлбөрийн хороо хагас бүтэн жил тутам үнэлж сургуульдаа тайлагнаж байна. Энэхүү үнэлгээний хүрээнд дараах чиглэлээр судалгаа хийж дүгнэн шинжилнэ.

- i. Сэтгэл ханамжийн үнэлгээ (суралцагчид, төгсөгчдөөс)
- ii. Явцын үнэлгээ (суралцагчийн ахиц дэвшилд үе шаттай хийх үнэлгээ)
- iii. Гүйцэтгэлийн үнэлгээ (Ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ)
- iv. Үр нөлөөний үнэлгээ (Мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх)
- v. Хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ, үнэлгээ
- vi. Хөтөлбөрийн чанарын үнэлгээ (чанарын үнэлгээ, судалгааг тодорхой үе шат давтамжтайгаар хийж үр дүнг хөтөлбөрийг хөгжүүлэх, сайжруулах бодлого шийдвэрт ашигладаг байх)

2.11.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 5 жилийн дотор магадлан итгэмжлэл /дотоод, гадаад/ хийлгэсэн байна.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Удирдлагын нэгж

3.1.1. Магистр, докторын сургалт эрхэлдэг сургууль нь энэ түвшний сургалтын ажил хариуцсан удирдлагын нэгжтэй байна. Энэхүү нэгжийн дарга (захирал, эрхлэгч) нь удирдах ажил буюу багшлах ажлын 3-аас доошгүй жилийн туршлагатай, судалгаа шинжилгээний ажил хийдэг, докторын зэрэгтэй хүн байна.

3.1.2. Нэгж нь тухайн сургуулийн магистр, докторын сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн шалгалт болон магистр, докторын ажлын хамгаалалтыг зохион байгуулах, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх үүрэгтэй.

3.1.3. Магистрант, докторантад хичээл заах, семинар, судалгааны ажил удирдах нь тухайн сургуулийн багшийн хувьд багшийн ажлын үндсэн ачаалалд тооцогдоно.

3.1.4. Сургууль нь багш нарын судалгаа шинжилгээний ажил эрхлэх боломж, нөхцлийг бүрдүүлнэ.

3.1.5. Томсон Ройтерс, Скопус зэрэг дэлхийн шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй болон бусад хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн эрдэм шинжилгээний дотоод, гадаадын сэтгүүлийн жагсаалтыг сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн захирлын тушаалаар батална.

3.1.6. Магистр, докторын ажлыг хамгаалалтад оруулах зөвшөөрөл өгөх үйл ажиллагааг сургуулийн сургалтын журамд тусгана.

3.1.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын мэдээллийн системийг боловсруулан, мэдээллийн санг бүрдүүлэн, бүртгэл тооцоог цахимжуулна.

3.1.8. Сургалтын хөтөлбөрийг дүүргэж сургуулиас тогтоосон голч дүнгийн шаардлага хангасан, магистр, докторын ажлаа амжилттай хамгаалан, тухайн ажлаа хянан засварлаж, эцэслэн холбогдох этгээдэд хүлээлгэн өгсөн болон сургуулийн бусад шаардлагыг хангасан магистрант, докторантад захирлын тушаалаар магистр, докторын зэрэг олгохоор шийдвэрлэнэ.

3.2. Хөтөлбөрийн хороо

3.2.1. Сургууль нь хэрэгжүүлж байгаа магистр, докторын хөтөлбөр бүрээр түүнийг боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, аргазүйн болон чанарын удирдлагаар хангаж, үр дүнг хариуцах үүрэг бүхий Хөтөлбөрийн хороо ажиллуулна.

3.2.2. Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг Эрдмийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн сургуулийн захирал томилно. Хөтөлбөрийн хороог хамтарсан хэлбэрээр байгуулах, түүний бүрэлдэхүүнд холбогдох чиглэлийн нэр хүндтэй эрдэмтдээс оролцуулах асуудлыг сургуулийн журамд тусгана.

3.2.3. Хөтөлбөрийн хорооны ахлагч нь уг хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, үр дүнг хариуцаж тайлагнана.

3.3. Гадаад хэлний болон нэгдсэн шалгалт

3.3.1. Магистрант нийт судлах багц цагийн 20 багц цагийг судалсны дараа гадаад хэлний шалгалт өгнө.

3.3.2. Гадаад хэлний шалгалт, мэдлэгийн түвшинг сургуулийн сургалтын журамд тусгана.

3.3.3. Гадаад хэлийг судалсан багц цагийг доктор, магистрын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.

3.3.4. Докторант докторын ажлаа эхлүүлэхийн өмнө нэгдсэн шалтгалт өгсөн байна. Энэхүү шалгалтын дүн, сургуулийн журмаар тогтоосон бусад шаардлагыг хангасан байдлыг үндэслэн нэгжээс судалгааны ажлаа эхлүүлэх албан ёсны зөвшөөрөл олгоно.

3.3.5. Магистрын ажил бичээгүй төгсөгчдийн хөтөлбөр дүүргэснийг баталгаажуулах нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалтын зохион байгуулалт, дэг, үнэлгээний асуудлыг сургуулийн сургалтын журамд нарийвчлан тусгана.

3.4. Магистр, докторын ажил

3.4.1. Магистрант, докторантын судалгааны ажлын сэдэв, удирдагчаа сонгосон сонголтыг хүндэтгэн үзнэ.

3.4.2. Докторын ажлын сэдвийн онцлогийг харгалзан хоёр удирдагч томилж болно.

3.4.3. Удирдагч нь дараах үүрэг хүлээнэ.

- i. Магистрант, докторантын судалгааны ажлын сэдвээ сонгоход зөвлөх,
- ii. Суралцагчийн судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулахад зөвлөх,
- iii. Судалгааны ажил хийх болон магистр, докторын ажил бичих явцад тодорхой хуваарийн дагуу мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналт тавих,
- iv. Ажлын агуулгыг хэсэг бүрээр болон бүхэлд нь дүгнэх,
- v. Хөтөлбөрийн хороо зөвшөөрснийг үндэслэн магистр, докторын ажлыг хамгаалалтад оруулах зөвшөөрөл олгох,
- vi. Эрдэм шинжилгээний семинар зохион байгуулж, суралцагчийн судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэх;
- vii. Амжилттай суралцаж байгаа магистрант, докторантыг хөтөлбөрийн хүрээнд судалгааны болон сургалтын туслах ажилтнаар ажиллах боломж олгож болно.

3.4.4. Удирдагчийн хүлээх хариуцлага, холбогдох арга хэмжээг сургуулийн журамд тусгана.

3.4.5. Гадны байгууллагын судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг ажилтныг удирдагчаар ажиллуулах тохиолдолд сургуулийн үндсэн багшийн нэгэн адилаар магистр, докторын судалгааны ажлыг удирдах, хамгаалахад ижил үүрэг хариуцлага хүлээлгэнэ. Энэ талаар сургуулийн сургалтын журамд нарийвчлан тусгана.

3.4.6. Магистрантын судалгааны ажлын үр дүнг энэхүү журмын 3.1.5-д заасан сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр хэвлүүлсэн байна. Докторант нь энэхүү журмын 3.1.5-д заасан сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор 1-ээс доошгүй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна.

3.4.7. Энэхүү журмын 3.4.6-д заасан шаардлагыг хангаагүй докторын ажлыг Хамгаалуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүй.

3.4.8. Докторын ажилд /диссертаци/ дараах шаардлага тавина.

- шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн эсхүл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй онол, арга зүйн зохих түвшинд шийдсэн байх;

- докторантын дэвшүүлж буй шинэ шийдлийн үндэслэлээ шинжлэх ухааны үндэслэлтэй нотолсон, урьд өмнө хийгдсэн мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, шүүмжлэлтэйгээр шинэлэг талыг нээн харуулсан байх;

- зохих загвар, шаардлагыг баримталсан, харилцан уялдаа, шүтэлцээтэй, шинжлэх ухааны хэлний хэм хэмжээний дагуу туурвисан байх;

- судалгааны үр дүнгийн үнэнийг нотолгоонд суурилан баталсан, дүгнэсэн байх ба судалгаанд ашигласан эх сурвалжийг заавал эш татаж, судлаачийн ёс зүйг эрхэмлэнэ. Эшилсэн бүх эх сурвалж докторын ажлын агуулгатай нийцсэн байна.

3.4.9. Докторын ажлыг монгол хэл дээр бичнэ. Докторын ажлын товч хураангуй /автореферат/-г англи хэл дээр 3 хуудаст багтаан бичиж, докторын ажилд хавсаргана.

3.4.10. Зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн магистр, докторын ажлын 2-оос доошгүй хувь дээр удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурна. Магистрын ажлын хувийг тухайн сургуулийн номын санд заавал хүлээлгэн өгнө.

3.4.11. Докторын ажлын хувийг Үндэсний номын сан, Шинжлэх ухаан, технологийн сан, тухайн сургуулийн номын санд заавал хүлээлгэн өгнө.

3.4.12. Сургууль магистр, докторын ажлыг электрон хэлбэрээр авч мэдээллийн сан бүрдүүнэ.

Дөрөв. Хамтын ажиллагаа, хамтарсан хөтөлбөр

4.1. Сургуулиуд /дотоод, гадаадын/ хамтарсан, салбар хоорондын хөтөлбөр хэрэгжүүлэх тохиолдолд багц цагийг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг холбогдох хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллагын шаардлагад нийцүүлэн сургууль хооронд байгуулсан албан ёсны гэрээгээр зохицуулна.

4.2. Гадаадын их дээд сургуулиудтай магистр, докторын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг зохих журмын дагуу авсан байна.

4.3. Хөтөлбөр нь дотоод, гадаадын нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй сургуулийн хөтөлбөртэй харьцуулах боломжтой байна.

4.4. Сургууль нь хөтөлбөрөө хэрэгжүүлэхэдээ төр, болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, ажил олгогчидтой харилцан үр дүнтэй хамтран ажиллана.

---o0o---